

**Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал  
/2018 оны 11-р дүгээр сар/**


Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO<sub>2</sub>), азотын давхар исэл (NO<sub>2</sub>), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O<sub>3</sub>) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар болон химийн аргаар тодорхойлж байна.

2018 оны хүйтний улирлын 11 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM10 тоосонцор 58 мкг/м<sup>3</sup>-ээр буюу 39%-аар, хүхэрлэг хий 5 мкг/м<sup>3</sup>-ээр буюу 18%-аар тус тус их байсан бол PM2.5 тоосонцор 17 мкг/м<sup>3</sup>-ээр буюу 14%-аар, азотын давхар исэл 9 мкг/м<sup>3</sup>-ээр буюу 17%-аар бага байлаа.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м <sup>3</sup>	
	Хүлцэх агууламж, мкг/м <sup>3</sup>	2017 оны 11-р сар	2018 оны 11-р сар
PM10 тоосонцор	100	150	208↑
Хүхэрлэг хий, SO <sub>2</sub>	50	28	33↑
PM2.5 тоосонцор	50	125	108↓
Азотын давхар исэл, NO <sub>2</sub>	50	54	45↓

Улаанбаатар хотын сүүлийн 3 жилийн хүйтний улирал дахь гол бохирдуулах бодис тус бүрийн сарын дундаж агууламжийг дараах хэсэгт харуулав.


**PM10 тоосонцор**



Зураг 1. Хүйтний улирлын PM10 тоосонцорын сарын дундаж агууламж, 2015-2018 он

Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын 2018 оны 11 дүгээр сарын дундаж агууламжийг 2017 оны мөн үетэй харьцуулахад 58 мкг/м<sup>3</sup>-ээр буюу 39%-иар их, Агаарын чанарын стандарт дахь Хүлцэх агууламж /цаашид АЧС дахь ХА гэх/-тай харьцуулахад 2.1 дахин их байна (Зураг 1).


### PM2.5 тоосонцор



Зураг 2. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2015-2018 он

Агаар дахь PM2.5 тоосонцрын 2018 оны 11 дүгээр сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17мкг/м<sup>3</sup>-ээр буюу 14%-иар бага, АЧС дахь ХА-аас 2.2 дахин их байна (Зураг 2).


### Хүхэрлэг хий (SO<sub>2</sub>)



Зураг 3. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2015-2018 он

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн 2018 оны 11 дүгээр сарын дундаж агууламжийг 2017 оны мөн үетэй харьцуулахад 5 мкг/м<sup>3</sup>-ээр буюу 18%-аар их байсан хэдий ч АЧС дахь ХА-аас хэтрээгүй байна (Зураг 3).

**Азотын давхар исэл (NO<sub>2</sub>)**



Зураг 4. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2015-2018 он

Агаар дахь азотын давхар ислийн 2018 оны 11 дүгээр сарын дундаж агууламжийг 2017 оны мөн үетэй харьцуулахад 9 мкг/м<sup>3</sup>-ээр буюу 17%-аар бага, АЧС дахь ХА-аас даваагүй байна (Зураг 4).

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
**ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**